

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах хуулийн болон
практик үндэслэл, шаардлага**

“Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 17 дугаар тогтоолын нэг дэх хэсгийн 10-т “шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй, нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчны хүрээнд шийдвэрлэх, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Монгол Улсын Ерөнхий сайдад даалгасан.

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл болон Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасны дагуу Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолоор Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг батлан гаргасан.

Эдгээр эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан заалт, дэвшүүлсэн зорилт, шийдвэр нь Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн бодит үндэслэл, шаардлагыг бүрдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 1996 онд “Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай” хуулийг батлан мөрдүүлж, академийн үйл ажиллагааг хууль, эрх зүйн хувьд зохицуулж ирсэн.

Сүүлийн жилүүдэд Инновацийн тухай хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого, Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм

технологийн жагсаалт зэрэг бодлого, эрх зүйн баримт бичгүүд шинээр батлагдан хэрэгжиж байна.

Улс орны болон салбарын хөгжлийн бодлого, эрх зүйн шинэчлэл, дэлхийн улс орнуудын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан энэхүү хуульд зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулах хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

1996 онд баталсан ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуульд академийн эрх зүйн байдал, хэрэгжүүлэх чиг үүргийг оновчтой тодорхой тусгаагүй, зөвлөх дэмжлэг үзүүлэх зэрэг идэвхигүй чиг үүрэгтэй байхаар зохицуулсны улмаас тус байгууллагын нийгэмд эзлэх байр суурь ач холбогдол буурч байна гэж дүгнэж болохоор байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлыг тодотгож улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр 7 заалт нэмж тусгах, 10 заалтад нэмэлт өөрчлөлт оруулах зохицуулалтыг хийв.

ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуульд дараах 6 чиглэлээр нэмэлт өөрчлөлтийг оруулна. Үүнд:

1. ШУА-ийн эрх зүйн байдлыг хэт ерөнхий оновчтой бус тодорхойлсныг шинэчлэн томъёолох;

2. ШУА-ийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор академийн удирдах дээд байгууллага, бүтцийн нэгжүүдийн чиг үүргийг тодотгож, удирдлагын бүрэн эрхийн хугацааг тодорхойлохоор;

3. Шинжлэх ухааны Академийн чиг үүргийг улс орны нийгэм эдийн засгийн томоохон төсөл хөтөлбөрүүдэд хараат бус хянан магадлагаа хийх чиглэлээр өргөжүүлэхээр,

4. ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний байгууллагуудыг Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн томъёолохоор;

5. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Шинжлэх ухааны Академийн гишүүдэд академич хэргэм хүртээж буй зохицуулалтыг хуульчлахаар;

6. Шинжлэх ухааны Академийн чиг үүрэгтэй уялдуулан Үндэсний түүх, хэл, соёл, угсаатны зүй, археологи, палеонтологийн эрдэм шинжилгээний музейг Академийн харьяанд ажиллуулахаар хуулийн төсөлд нэмж тусгав.

Гурав. Хуулийн төсөл батлагдсанаар үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар гарах нийгэм, эдийн засгийн үр дагаврыг дараах байдлаар төсөөлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгагдсан стратегийн зорилтууд, Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2025 он хүртэл хөгжүүлэх зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн нөхцөл боломж бий болно.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар тус салбарт нэгэнт бүрэлдэн бий болсон оюуны болон материаллаг нөөц, чадавхийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшилд бүрэн дүүрэн ашиглах хууль, эрх зүйн нөхцөл боломж бүрдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар шинээр байгууллага, бүтэц үүсэхгүй бөгөөд үүнтэй холбоотой нэмэлт хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи санал.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр бусад хууль тогтоомжтой нийцнэ.

Холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.